

ХОВД АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, шинэчлэлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогын хүрээнд төрийн үйлчилгээг шуурхай болгож, өмнөх жилүүдэд олсон амжилт, хөгжил дэвшлийг баталгаажуулан иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьдралын таатай нөхцөлийг бүрдүүлэхэд аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилго оршино.

Нэг. Төрийн удирдлага, эрх зүйн бодлогын хүрээнд:

1.1. Төрийн байгуулалтын талаар:

1.1.1. Төрийн албаны үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй болгох ажлыг үргэлжлүүлнэ.

1.1.2. Төрийн байгууллагын удирдах ажилтан, мэргэжилтнүүдэд тавигдах шаардлага, шалгуурыг өндөржүүлнэ.

1.1.3. Боловсон хүчнийг сургаж дадлагажуулах замаар төрийн албан хаагчдын чадавхийг дээшлүүлнэ.

1.1.4. Аймгийн Засаг даргын захирамж, Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлын мэдээллийг иргэдэд ил тод мэдээлж, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, иргэдийн санал бодлыг сонсох “Иргэдийн өдөрлөг”-ийг нэгдсэн хуваарийн дагуу зохион байгуулна.

1.1.5. Аймгийн иргэний танхимуудын үйл ажиллагааг дэмжиж, орон нутгийн тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг иргэдээрээ хэлэлцүүлэн шийдвэрлэж хэвшинэ.

1.1.6. “Цахим засаглал” хөтөлбөрийг хэрэгжүүлэн төрийн байгууллагаас гаргасан шийдвэрүүдийг цахим мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд хүргэж, иргэд санал хүсэлт, өргөдөл, гомдлоо чөлөөтэй илэрхийлэх, хариугаа бичгээр болон цахим хэлбэрээр түргэн шуурхай авах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.1.7. Нутгийн удирдлага, захиргааны байгууллагаас дэвшүүлсэн хөтөлбөр зорилтыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагын бодит санал санаачлага, төсөл хөтөлбөрийг дэмжиж хамтран ажиллана.

1.1.8. Улаанбаатар хотод аймгийн төлөөлөгчийн газар ажиллуулна.

1.1.9. Сумдаас ирүүлсэн санал, судалгааг үндэслэн сумдын ЗДТГ-ын автомашин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шинэчлэх, багийн Засаг дарга нарыг унаажуулах, багийн төвүүдийн барилгыг шинээр барих асуудлыг шийдвэрлэнэ.

1.1.10. Уламжлалт харилцаатай орнуудын хамтын ажиллагааг бэхжүүлж оюутан сургах, солилцох, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

1.1.11. Аймагт хөрөнгө оруулагчдын олон улсын чуулга уулзалтыг зохион байгуулна.

1.1.12. Сум, байгууллагуудын үйл ажиллагаанд хоёроос доошгүй удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

1.1.13. Хууль тогтоомж, төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилт төрийн үйлчилгээ иргэдэд хэрхэн хүрч байгаа, орон нутгийн удирдлагын болон төрийн албан хаагчдын үйл ажиллагааны талаар иргэдээс авах санал асуулгыг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

1.1.14. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ном гарын авлага болгож хэвлүүлнэ.

1.1.15. Галданбошгот хааны мэндэлсний 370 жилийн ой, баруун бүсийн морин эрдэнийн даншиг наадмыг зохион байгуулна.

1.2. Эрх зүйн бодлогын талаар:

1.2.1. Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

1.2.2. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.

1.2.3. “Эрх зүйн мэдээллийг иргэн бүрт” хөтөлбөр батлан хэрэгжүүлнэ.

1.2.4. Авлигатай тэмцэх нэгдсэн хөтөлбөр батлан хэрэгжүүлнэ.

1.2.5. Төрийн архивын үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангана.

1.2.6. Хил хамгаалах ажилд дэмжлэг үзүүлнэ.

1.2.7. Мал, түүхий эдийн захыг хотын төвөөс гаргах, хотын төвд мал оруулахгүй байх шийдвэр гаргаж хэрэгжүүлнэ.

1.2.8. Түлшний захыг хотын зах руу гаргах шийдвэр гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Хоёр. Нийгмийн бодлогын хүрээнд:

2.1. Боловсролын чиглэлээр:

2.1.1. ЕБС-д суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, суурь боловсролын хамран сургалтыг 93.6 хувьд хүргэнэ.

2.1.2. Багуудад гэр цэцэрлэг байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулан, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 78.5 хувьд хүргэж, цэцэрлэг байгуулах, хүүхэд харах, асрах үйлчилгээ нээж ажиллуулахыг дэмжинэ.

2.1.3. Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил, ёс зүй, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Багшийн хөгжил” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.1.4. Хүүхдийн авъяас, билгийг багаас нь нээн хөгжүүлэх зорилгоор “Авъяас”, “Ном”, “Оюунлиг-Ховд” хөтөлбөрийг бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан олон нийтийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлж, Монгол ухаан, зан заншил, үлгэр, туульсын гэр өргөө ажиллуулна.

2.1.5. Үндэсний лаборатори сургуулийн үйл ажиллагааг бэхжүүлж, сургалтын дэвшилтэт технологийг орон нутгийн онцлогтой уялдуулан нэвтрүүлнэ.

2.1.6. Насан туршийн боловсрол төвийг байгуулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэн иргэдэд амьдрах ухааны боловсрол олгох насан туршийн боловсролын нэгжийн үйл ажиллагааг тогтмолжуулна.

2.1.7. Сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагын мэдээлэл харилцааны технологийн тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулж, цахим сургуулийн тоог нэмэгдүүлнэ.

2.1.8. Дотуур байрны үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, тоног төхөөрөмжийг сайжруулна.

2.1.9. Мөст, Чандмань сумын сургуулийн дотуур байрны барилгыг шинээр барьж эхлүүлнэ.

2.1.10. Дөргөн, Үенч, Чандмань, Жаргалант сумын I сургуулиудын барилгын өргөтгөлийг барьж ашиглалтанд оруулна.

2.1.11. Засгийн газрын тогтоолоор орон сууцаар хангагдах албан тушаалтан, орон нутагт чухал шаардлагатай, нарийн мэргэжлийн өндөр ур чадвартай эмч, багш, инженер, технологич нарт зориулсан орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

2.1.12. Ховд их сургууль, “Хөгжил” политехник коллежийг түшиглэн инноваци технологийн инкубатор төвийг байгуулна.

2.1.13. “Хөгжил” политехник коллежийн техник технологийн шинэчлэл хийж, сургалтын хөтөлбөрийг нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцүүлэн шинэчилж, түншлэлийг өргөжүүлнэ.

2.1.14. ХоИС-д сургуулийн өмнөх боловсролын багш, инженер техникийн мэргэжилтэн бэлтгэх ангиудыг шинээр нээж, ерөнхий боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг өргөжүүлнэ.

2.1.15. Аймаг, бүсийн түвшинд хэрэгжүүлж буй хөгжлийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдтэй холбоотой хэрэглээний болон бодлогын судалгааг хэрэгжүүлж, орон нутгийн чадавхийг бүрдүүлнэ.

2.1.16. “Шинжлэх ухаан технологийн парк” байгуулах судалгааны чиглэлээр Шинжлэх ухааны академитай хамтран ажиллана.

2.1.17. Баруун бүсийн хүүхдийн нэгдсэн чуулган, ардын язгуур урлагийн наадмыг зохион байгуулна.

2.1.18. Залуучуудын хөгжлийн төвийг байгуулж, мэдлэг, чадвартай, хариуцлагатай, өөртөө итгэх зан үйл бүхий амьдарлын ур чадвартай өсвөр үе, залуучуудыг төлөвшүүлэхэд анхаарч ажиллана.

2.1.19. Залуучуудын төрийн бус байгууллагаас дэвшүүлж буй санал санаачилгыг дэмжиж ажиллана.

2.2. Эрүүл мэндийн чиглэлээр:

2.2.1 Жил бүр иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношлогоо, шинжилгээнд хамруулж, өвчнийг эрт оношлон эрүүлжүүлэх ажлыг графикаар зохион байгуулна.

2.2.2. “Эрүүл эхээс эрүүл хүүхэд” зарчмыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний бүх шатанд хэрэгжүүлэн, эх хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулж, Мянганы хөгжлийн зорилтыг хангана.

2.2.3. Нийгмийн эрүүл мэнд ялангуяа халдварт болон халдварт бус өвчин, амны хөндийн эрүүл мэнд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж, эрүүл хот, сум, гудамж, байгууллага, өрхийг дэмжих хөдөлгөөнийг өрнүүлнэ.

2.2.4. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Бельгийн Засгийн газрын чадавхжуулах төслийг эрчимжүүлж, оношлогооны төвийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.

2.2.5. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн болон амралт, сувиллын төв байгуулах санал санаачилга, үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

2.2.6. Сумдын эрүүл мэндийн төвийг гал тогооны цахилгаан хэрэгслээр хангах арга хэмжээг дэс дараатайгаар шийдвэрлэнэ.

2.2.8. Зарим сумдын эмнэлэг, Жаргалант сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдийг цэвэр бохир усны сүлжээнд холбоно.

2.2.9. Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон 2-3 сумын түргэн тусламжийн автомашиныг шинэчилнэ.

2.2.10. Сумдын эрүүл мэндийн төвийг ээлж дараатайгаар зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар хангана.

2.2.11. Байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэн судлах төвийн шинэ барилгын ТЭЗҮ, зураг төсвийг хийлгэнэ.

2.2.12. Эмийн сангийн стандартыг хэрэгжүүлж, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг сайжруулан эмнэлгүүдийн стационарт хэрэглэгдэх эмийг тендерээр хангах хувийг нэмэгдүүлнэ.

2.2.13. “Эмийн зохистой хэрэглээний загвар аймаг” хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдэд зөв зан үйлийг төлөвшүүлэх ажлыг өргөжүүлнэ.

2.2.14. “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх” хөтөлбөр боловсруулан батлуулж хэрэгжүүлнэ.

2.2.15. Эрүүл мэндийн салбарын судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

2.2.16. Анхан шатны нэгжид ажиллаж буй эмч нарыг удирдахуйн менежментийн сургалтад хамруулж, тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ.

2.3. Соёл, спорт аялал жуулчлалын чиглэлээр:

2.3.1. Өв соёлын хүрээлэнгийн үзмэрийг нэмэгдүүлж ардын зан үйлийг төлөвшүүлэх ажлыг өргөжүүлнэ.

2.3.2. Аймгийн музейд Монгол улсын Ерөнхийлөгчийн танхим байгуулна.

2.3.3. Номын сангуудын фондыг орчин үеийн шинжлэх ухаан, технологийн мэдээлэл, мэдлэг агуулсан номоор баяжуулан цахим номын сангийн үйлчилгээг өргөжүүлнэ.

2.3.4. “Аваргууд” хөтөлбөрийг хэрэгжүүлж, тамирчдын бэлтгэл хийх орчин, нөхцөлийг сайжруулж, улсын болон олон улс, бүсийн тэмцээнийг 2-оос доошгүй төрлөөр зохион байгуулан өндөр амжилт гаргасан тамирчдыг урамшуулна.

2.3.5. Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн үйл хэрэг болгох хөдөлгөөн өрнүүлнэ.

2.3.6. Олон үндэстэн ястны соёлын өвийг хадгалж хамгаалах, судлан сурталчлах, нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Алтан өв” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.3.7. “Авъяаслаг Ховдчууд” болон олон улсын хөөмийн наадмыг зохион байгуулна.

2.3.8. Жаргалант суманд соёл спортын цогцолбор, Үенч суманд соёлын төвийн барилга барина.

2.3.9. Манхан, Ховд сумын спорт цогцолборын барилгыг ашиглалтанд оруулна.

2.3.10. Түүх соёлын биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалтыг фото болон цахим бүртгэлд бүртгэлжүүлэх ажлыг өргөжүүлнэ.

2.3.11. Төв цэнгэлдэх хүрээлэнг засварлана.

2.4. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр:

2.4.1. 500 хүний байнгын ажлын байр бий болгох хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, мэргэжлийн түр сургалтад 450 хүнийг хамруулан 60 хувийг нь ажлын байраар хангана.

2.4.2. “Ажилд авсан хүн тутамд нэг сая төгрөг” хөтөлбөрийг хэрэгжүүлж ЖДҮ-ийн зээлээр аж ахуйн нэгжийг дэмжинэ.

2.4.4. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн үйл ажиллагааг тотмолжуулна.

2.4.5. Хүүхдэд сар бүр 20000 төгрөг олгох төрийн бодлогыг орон нутагт зохион байгуулж Нийгмийн халамж, тусламж авах иргэдийг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

2.4.6. Бүтэн өнчин хүүхдэд аймгийн Засаг даргын тэтгэлэг олгож, эрсдэлд байгаа хүүхэд, гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг тогтмолжуулна.

2.4.7. Олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээг иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор зорилтот бүлгүүдэд хүргэнэ.

2.4.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулна.

2.4.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийтийн тээврээр хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.

2.4.10. Усны үнийг нэг төгрөг болгох зорилтын хүрээнд эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан хувийн хэвшлийн худгуудад нөхөн олговор өгнө.

Гурав. Эдийн засаг, үйлдвэрлэл, худалдаа, дэд бүтэц, барилга, хот байгуулалт, газрын харилцааны талаар:

3.1. Санхүү эдийн засаг, төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар:

3.1.1. Орон нутгийн татварын хувь хэмжээг оновчтой тогтоон татварын бааз суурийг өргөжүүлэх замаар орон нутгийн төсвийн орлогын хэмжээг нэмэгдүүлж, цахим тайлангийн системийг бүрэн хэрэгжүүлнэ.

3.1.2. Татвар төлөгчдөд бүсчилсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах, тоон гарын үсгийг нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалт, тайлангийн дараах ногдуулалтын хяналтын үр нөлөөг дээшлүүлж, далд эдийн засгийг илрүүлэх замаар орлогыг бодитойгоор тайлагнаж, татвар төлөлтийг нэмэгдүүлнэ.

3.1.3. Сангуудын зориулалтыг судалж, зарим сангуудыг нэгтгэн шинэчилсэн журам боловсруулан хэрэгжүүлж, сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, эргэн төлөлтийг сайжруулна.

3.1.4. Төсвийн тухай хууль, заавар, журмын хэрэгжилт, цаг үеийн ажлын талаар сургалт зохион байгуулах, төсвийн шинэ программ нэвтрүүлэх, тоног төхөөрөмж шинэчлэх замаар “шилэн данс”-ны тогтолцоог нэвтрүүлж, төсвийн ил тод байдлыг хангана.

3.1.5. Төсвийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын нягтлан бодогч, нярав, төрийн сангийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, сэлгэн ажиллуулах, нягтлан бодох бүртгэл болон тайлан тэнцлийг программаар гаргах, төрийн сангийн үйлчилгээг хүргэх, шуурхай болгох, төсвийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулна.

3.1.6. Улс, орон нутаг, ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлд хөндлөнгийн болон дотоодын аудит хийлгэн үнэлэлт дүгнэлт өгөх замаар ажлын гүйцэтгэлийн үр ашгийг дээшлүүлнэ.

3.2. Үйлдвэрлэл, худалдааны талаар:

3.2.1. Шинжлэх ухаан, үйлдвэрлэл технологийн паркийг байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулна.

3.2.2. Аймгийн төвд баригдаж буй ахуйн үйлчилгээний төвийн барилгыг ашиглалтанд оруулж, бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллуулна.

3.2.3. Сумдад ахуйн үйлчилгээ, бизнес инкубатор төв байгуулах санаачилгыг дэмжиж, шинээр жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг бойжуулах, зах зээлд гарахад нь туслах үйлчилгээ үзүүлнэ.

3.2.4. Жаргалант суманд Баруун бүсийн худалдааны төв-битүү захын барилгын ажлыг дуусгаж, ашиглалтанд оруулна.

3.2.5. Буянт суманд төмс боловсруулах үйлдвэр байгуулна.

3.2.6. Жаргалант, Дуут сумын рашаан усыг судалж, рашаан савлах жижиг үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжинэ.

3.2.7. Дөргөн суманд ингэний ундаа савлах цех, жижиг үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжинэ.

3.2.8. Жаргалант суманд шахмал болон хийн түлшний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.3. Дэд бүтцийн талаар:

3.3.1. Түгээмэл тархацтай барилгын материалын ордуудын судалгаа явуулж нөөцийг нь тогтоон, орон нутагт тохирсон барилгын материалын үйлдвэр байгуулах техникийн нөхцөл, стандартуудыг батлуулж, тэдгээрийн хэрэглээний талаар технологийн зөвлөмжүүдийг гаргаж ажиллана.

3.3.2. Ховд-Өлгий чиглэлийн 189.7 км хатуу хучилттай авто замын ажлыг эхлүүлнэ.

3.3.3. "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын төсөл"-ийн хүрээнд Бага улаан даваа-Тэмээн хүзүү чиглэлийн 110.8 км замыг үргэлжлүүлэн барьж ашиглалтанд оруулна.

3.3.4. "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын төсөл"-ийн хүрээнд Манхан-Бага улаан даваа чиглэлийн 103.3 км хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барина.

3.3.5. Булганы Хөвч-Үенч, Үенч-Тэмээн хүзүү чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барьж ашиглалтанд оруулна.

3.3.6. Мянгадын гүүр-Сар хайрхан чиглэлд хатуу хучилттай 20 км зам барина.

3.3.7. Хотын төв, гэр хорооллын авто болон явган хүний замыг шинээр байгуулж гэрэлтүүлэгтэй болгоно. Явган хүний замыг шөнө гэрэлтдэг фосфортой жишиг зам болгох эхлэлийг тавина.

3.3.8. Зэрэг, Алтай, Манхан сумдад 1-3 км хайрган болон хатуу хучилттай авто зам, явган хүний замыг орон нутгийн санаачилгаар байгуулах ажлыг эхлүүлнэ.

3.3.9. Аймгийн авто замын нэгдсэн сүлжээний зураглалыг шинэчлэн боловсруулж, замын сүлжээний тэмдэг тэмдэглэгээ хийнэ.

3.3.10. Аймгийн төвд 5.0 км хатуу хучилттай авто зам шинээр барина.

3.3.11. Ховд хотын үерийн хамгаалалтын даланд засвар хийж, зарим хэсгийг нь инженерийн хийцтэй болгоно.

3.3.12. 12 сумыг интернэтийн өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд, зарим багуудыг үүрэн холбооны сүлжээнд холбоно.

3.3.13. Хөшөөтийн уурхайн орчимд дулааны цахилгаан станц байгуулах судалгаа хийлгүүлж, нүүрс баяжуулах ажлыг эрчимжүүлнэ.

3.3.14. Аймгийн төвийн эрчим хүчний найдвартай хангамжийг бий болгохын тулд шинээр 35/6 кВ-ийн дэд станц байгуулна.

3.3.15. Рашаант багийн шинэ суурьшлын бүсэд 250 кВа чадалтай дэд станц, гэрэлтүүлэг, ЦДАШ-ыг иж бүрнээр барьж байгуулна.

3.3.16. Бичигт баг, Малчны хороололд шинээр 250 кВа дэд станц, 1 км ЦДАШ барина.

3.3.17. Ярантын заставыг ЦДАШ-д холбоно.

3.3.18. Жаргалант сумын талын хашаа болон Рашаант, Наран багийн хатуу хучилттай авто замаас дээш цэвэр, бохир усны шугам, сүлжээний өргөтгөлийн судалгаа хийж, хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэн жишиг гэр хорооллыг цэвэр, бохир ус, халаалтын системд дэс дараатай холбоно.

3.3.19. Ховд хотод утасгүй интернэтийн сүлжээ байгуулна.

3.4. Барилга, хот байгуулалт, газрын харилцааны талаар:

3.4.1. Ховд хотын ерөнхий төлөвлөгөөг тодотгон шинэчлэн баталж, Монгол улсын жишиг “Ховд хот” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.4.2. Хувийн орон сууцны хороолол байгуулах газрыг нэгдсэн журмаар гаргаж инженерийн байгууламжийг байгуулан иргэд өөрсдөө хувийн орон сууц барих нөхцөл бүрдүүлнэ.

3.4.3. Ховд хотод 1000 айлын орон сууцны инженерийн байгууламжийг үе шаттай байгуулж, орон сууц барих ажлыг хувийн хэвшлийн оролцоотойгоор эхлүүлнэ.

3.4.4. 160, 108 айлын орон сууцны хорооллын гадна зам талбайг тохижуулах, ногоон байгууламж хийж хорооллын доторх зам, явган хүний замыг барина.

3.4.5. Газрын тухай хуулийг хэрэгжүүлж, өмчлүүлэх, эзэмшүүлэх газрыг аймаг, сумын хэмжээнд нарийвчлан тогтоож, 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ИТХ-аар батлуулан мөрдөнө.

3.4.6. Нэг суманд “Шинэ сумын төв” төсөл хэрэгжүүлнэ.

3.4.7. Нисэх буудалд аэродромын зураглалын өгөгдлийн сан бүрдүүлнэ.

Дөрөв. ХАА, байгаль орчны бодлогын хүрээнд:

4.1. Хөдөө аж ахуйн талаар:

4.1.1. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

4.1.2. Малын гоц халдвар, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга үйлчилгээний төсвийг хоёр дахин нэмэгдүүлнэ.

4.1.3. Мах, ноосны чиглэлийн Торгууд, Сутай хонь, ноолуурын чиглэлийн Алтайн улаан ямааны удмын санг хамгаалах, малчид, иргэн, аж ахуйн нэгжийг стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчээр хангах зорилгоор орон нутгийн өмчийн цөм сүргийн аж ахуйн нэгж байгуулна.

4.1.4. Ноолуурын чиглэлийн Бумбатын улаан ямааны аж ахуй биологийн ашигтай шинж чанар, нэгжээс авах ашиг шим, эдийн засгийн үр ашгийг үргэлжлүүлэн судалж омгоор баталгаажуулна.

4.1.5. Малын индексжүүлсэн даатгалд нийт малчин өрхийн 10-аас доошгүй хувийг хамруулна.

4.1.6. Бэлчээрийн хортон шавьжтай тэмцэх арга хэмжээг 30,0 мянган га-гаас доошгүй талбайд зохион байгуулж, шинээр хортон шавьж, мэрэгч тархаж байгаа газар нутгийн судалгаа гаргаж, тархацыг бууруулна.

4.1.7. Орон нутагт халдварт өвчний голомтыг устгах, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардлагатай багуудад мал угаах ванн барьж, мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулна.

4.1.8. Уулын бүсийн 4 сумын малчдад зориулж хадлангийн талбайг гэрээгээр эзэмшүүлнэ.

4.1.9. Хөдөө аж ахуйн түүхий эдийн цэвэрлэх байгууламж барина.

4.2. Байгаль орчны талаар:

4.2.1. Үйлдвэрлэл, зам, барилга, геологи, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр бэлтгэж буй төслүүдийг байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээнд хамруулж нөхөн сэргээлтийг хийлгэнэ.

4.2.2. Ашигт малтмалын хайгуул хийх, олборлох нөхцөлд багийн иргэдийн нийтийн хурлын шийдвэрт үндэслэн зөвшөөрөл олгодог болно.

4.2.3. Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг экосистемийг судалж тогтоон, тухайн нутгийн нийгэм-экологийн тогтолцооны дасан зохицох чадавхийг нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

4.2.4. Орон нутгийнхаа байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах зорилгоор байгуулагдан ажиллаж буй малчдын бүлэг, байгаль хамгаалах нөхөрлөлүүдийг дэмжинэ.

4.2.5. Аймаг, сумдын төвд ногоон байгууламж бий болгох, мод тарих ажлыг эрчимжүүлж урамшуулал олгодог тогтолцоог нэвтрүүлнэ.

4.2.6. Байгаль экологийн өвөрмөц тогтоцтой, ховордсон ургамал, амьтан элбэгтэй газар нутгийг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл боловсруулж, шийдвэр гаргагчдад хүргүүлнэ.

4.2.7. Ховд хотын агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр боловсруулж, “Цэвэр агаар” төслийг хэрэгжүүлнэ.

4.2.8. Ховд хотын зам дагуу болон байгууллага, аж ахуйн нэгж бүр эзэмшил газрынхаа 10–аас дээш хувийг шат дараатайгаар ногоон байгууламжтай болгох зорилтыг хэрэгжүүлнэ.

4.2.9. Эко сургуулиудын сүлжээг өргөтгөн байгаль хамгаалах үйл ажиллагаанд эко сургуулиудыг татан оролцуулж, гаргасан санал санаачилгыг дэмжинэ.

4.2.10. Судалгааны үндсэн дээр орон нутгийн бага урсацтай голуудад ус хуримтлуулах сан, хөв, цөөрөм, далан байгуулж, малын тэжээлийн ургамал, жимс жимсгэний мод, өрхийн тариалан эрхлэх, малчдын усан хангамжийг сайжруулах санал санаачилгыг дэмжинэ.

4.2.11. Говийн унаган ургамал заг, шавгийг түлшинд хэрэглэхийг хориглож, нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг дэмжинэ.

4.2.12. Хус, балгана модыг хамгаалах, нөхөн сэргээх ажилд дэмжлэг үзүүлнэ.

4.2.13. Ойн сан бүхий газруудыг гэрээгээр нутгийн иргэдийн нөхөрлөлд эзэмшүүлж, хамгаалах, нөхөн сэргээх санал санаачилгыг дэмжинэ.

4.2.14. “Ногоон хөгжлийн хөтөлбөр”-ийг батлуулж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

4.2.15. Цаг уурт зориудаар нөлөөлөхөд дэмжлэг үзүүлнэ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР